



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 1127

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл хүчингүй болгох тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Өмнөговь аймаг дах Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 2018/ШЦТ/164 дугаартай шийтгэх тогтоол, Өмнөговь аймаг дах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 01/387 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Отгонбаатарын Нямцэндэд олгосон ИЭТ0006769 сери, 0006769 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосугай.

2. О.Нямцэндийн эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай:

2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;

2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрх үүстэл буюу 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;

2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Яаралтай тусламж судлалын мэргэжлийн салбар зөвлөл /О.Оюунбилэг/, Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар /Ц.Өнөржаргал/, Өмнөговь аймаг дах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /Я.Батгэрэл/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

080698